



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 02 сарын 23 өдөр

Дугаар А/86

Хэрлэн сум

Ажлын хэсэг байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.5-ын "а", 33 дугаар зүйлийн 33.1, 33.1.2, Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 30.1.13, 30.1.15, Сонирхлын зөрчлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2, 7.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Япон улсын Засгийн газрын "Өвсний үндэс" хөтөлбөрийн сонгон шалгаруулалтад бүрдүүлэн ирүүлэх төслийн материалын жагсаалтыг үндэслэн тус хөтөлбөрийн хөрөнгө оруулалтаар 2017 онд хийгдэх Норовлин сумын сургуулийн дотуур байрны өргөтгөл барих ажлын гүйцэтгэгч болон аудит хийх компанийг тус тус сонгон шалгаруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Дарга:	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
Гишүүд:	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хэлтсийн дарга
	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга
	Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн
	Норовлин сумын ерөнхий боловсролын сургуулийн захирал
Нарийн бичгийн дарга:	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн

2. Сонгон шалгаруулах үйл ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулж, ашиг сонирхлын зөрчлийн мэдэгдэл тайлбарыг зохих журмын дагуу гаргуулж авахыг ажлын хэсгийн ахлагч /Г.Лхагвахатан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

01 458